

Менторшип-III


ЭМНЭЭЛЗҮЙН ТОХИОЛДОЛ-2

Ментор эмч – Зүрх судасны эмч, АУ- ны Доктор Ц.Намхайдорж

Ментий эмч нар – Б. Баярцогт

Э. Долгорсүрэн,

Ц. Цэрэндолгор



ЭМНЭЛЗҮЙН ТОХИОЛДОЛ

- Ч.С 74 настай, эрэгтэй.

Зовуурь: 2 хөл их даарч байнгын хүйтэн байх болсон, баруун талын хөл мэдээ алдана, хөлөө чирж доголж явна.

Өвчний түүх

- 3-4 жилийн өмнөөс хөлийн үзүүр хүйт даагаад үргэлж даарах болсон , 20-д хоногийн өмнөөс баруун талын хөл мэдээгүй болж хөлөө чирж явах болсон.
- 1990 онд – Артерийн гипертензи оношлогдсон, тэр үеэс даралт бууруулах эм тогтмол ууж эхэлсэн.
- 1992 онд тархинд цус харваж зүүн нүдний хараа муудаж юм харахаа больсон
- 2013 онд – Чихрийн шижин өвчин хэв шинж -2 оношлогдсон
- 2021 онд- Бөөрний үйл ажиллагааны алдагдалд орж эмчийн хяналтанд орсон.



АСУУМЖ

Амьдралын түүх

- 1949 онд айлын ганц хүүхэд болон мэндэлсэн. 35 жил нийтийн автобусны жолооч хийж байгаад 2006 онд тэтгэвэрт гарсан.

Мэс засал

- 2018 онд Түрүү булчирхай авах мэс засал

Халдварт өвчин

- Үгүйсгэнэ

Харшил

- Үгүйсгэнэ

Хорт зуршил

- Архи – Хааяа баяр ёслолоор хэрэглэнэ
- Тамхи – 15 наснаас эхлэн 59 жил татсан.

Удамшил

- Үгүйсгэнэ



ҮЗЛЭГ

- **Биеийн ерөнхий үзлэг:** Биеийн ерөнхий байдал дунд
- **Арьс хуурай, уян чанар багассан.**
- **Амьсгалын эрхтэн тогтолцоо:** Уушги 2 талд цулцангийн амьсгалтай, баруун доод хэсгээр амьсгал сул, сатураци – 98%
- **Зүрх судасны эрхтэн тогтолцоо:** Баруун гарт А/Д 154/76 мм.муб , зүүн гарт АД 168/80 мм.муб ЗЦТ- 76 удаа
- **Хоол боловсруулах эрхтэн тогтолцоо:** Хэл чийглэг, нимгэн цагаан өнгөртэй.
- **Шээс ялгаруулах эрхтэн тогтолцоо:** Шээсний гарц багассан.
- **Мэдрэлийн эрхтэн тогтолцоо:** Зүүн нүд хараагүй, баруун нүд харах чадвар буурсан
- **Хөлийн үзлэгт:** 2 хөл хүйтэн , арьс хуурайвтар , тавхайн судасны лугшилтыг *A.dorsalis pedis* , *a.tibialis posterior* дээр тэмтэрч үзэхэд лугшилт зүүн талд сулавтар, баруун талд тэмрэгдэхгүй.
- **ABI /ankle-brachial index/** - Баруун-0.3 , Зүүн – 0.43



ШИНЖИЛГЭЭНД

2023-10-13.н

- ЦЕШ-нд –д өөрчлөтгүй
- ШЕШ-нд - URO- 33umol/l ↑
 - Pro- 10g/l ↑
 - Glu- /++++/
- Биохими – TP – 5.9 g/dl ↓
 - Glu- 8 mmol/l ↑
 - T.Chol- 228mg/dl ↑
- Бүлэгнэлт- хэвийн
- HbA1C- 6.4% ↑



БАГАЖИЙН ШИНЖИЛГЭЭНД /CT-ANGIOGRAPHY/



ОНОШ

- **Үндсэн онош:** Чихрийн шижин өвчин хэвшинж-2 , хяналт муу
Артерийн гипертензи 2-р зэрэг
Бөөрний архаг дутагдал
- **Хүндрэл:** Чихрийн шижингийн үеийн хөлийн судасны хүндрэл, макроангиопати




ХИЙГДСЭН ЭМЧИЛГЭЭ- БАРУУН ХӨЛД /PERCUTANEOUS ANGIOPLASTY/



ХИЙГДСЭН ЭМЧИЛГЭЭ-БАРУУН ХӨЛД /PERCUTANEOUS ANGIOPLASTY/



ХИЙГДСЭН ЭМЧИЛГЭЭ-БАРУУН ХӨЛД /PERCUTANEOUS ANGIOPLASTY/



ABI /ANKLE-BRACHIAL INDEX/

- Баруун хэлд percutaneous angioplasty хийхийн өмнө
 - Баруун талд – ABI= 0.3
 - Зүүн талд – ABI= 0.43
- Баруун хэлд percutaneous angioplasty хийсэний дараа
 - Баруун талд – ABI= 1,06
 - Зүүн талд – ABI= 0,45



ЧИХРИЙН ШИЖИНГИЙН ХӨЛИЙН ХҮНДРЭЛ

- Чихрийн шижин өвчний хүндрэлүүдийн нэг бөгөөд доод мөчдийн цусан хангамжийн дутагдал болон мэдрэлжүүлэлт алдагдсанаас болж арьс, зөөлөн эд, яс үе холбооны гэмтлийн суурин дээр үүсдэг хурц болон архаг явцтай идээт үхжилт процессоор даамжирдаг эмгэг юм.
- Чихрийн шижин өвчний хөлийн хүндрэлүүд нь элбэг тохиолдохоос гадна эмчлэхэд төвөгтэй, эмчилгээний өртөг өндөртэй
- Чихрийн шижингийн хөлийн шархлаатай өвчтөн 5 жилийн дотор нас барах эрсдэл нь чихрийн шижингүй өвчтөнтэй харьцуулахад 2.5 дахин өндөр
- Чихрийн шижингийн хөлийн шархлаатай өвчтөний 20 орчим хувьд нь янз бүрийн түвшинд хөлийг тайрахад хүрдэг. ЧШӨ-н улмаас хөлөө тайруулсны дараах 5 жилийн доторх нас баралт нь 70%-с илүү байна.
- Монголд ЧШӨ-тэй хүмүүсийн 10,1% нь хөлийн шархлаатай, 3,1% хөл тайруулсан (2010 он Л.Батцэцэг магистрын ажил) байна



ЧИХРИЙН ШИЖИНГИЙН ХӨЛИЙН ХҮНДРЭЛ

Хөлийн хүндрэлийн эмнэлзүйн хэлбэрүүд


Эмнэлзүйн шинж тэмдэгүүд	Тавхайн мэдрэлжүүлэлт алдагдах хэлбэр	Тавхайн цусан хангамж хомсдох хэлбэр
Арьсны уян хатан байдал	Арьс хуурай хагарсан, даралт ихтэй хэсгүүдээр арьс зузаарсан	Тавхай хатингаршсан, арьс нь үрчгэр нугалаатай
Арьсны өнгө	Арьс улайсан хөл дулаан	Цайвар хөхөвтөр туяатай (хурууны үзүүрээр илүү), Хөл хүйтэн
Тавхайн хэлбэр алдагдсан байдал	Өвөрмөц деформацитай(Чарлотийн тавхай) , хавантай	Өвөрмөц бус деформацитай, хавангүй
A.Pedis dorsalis-н лугшилт	Хадгалагдана	Буурсан эсвэл байхгүй
Мэдрэхүйн байдал	Мэдрэхгүй	Мэдрэнэ
Тавхайн шархны байдал	Хэсэгчилсэн шархтай, ихэвчлэн их даралт авдаг хэсэг болох тавхайн хэсэгт	Тархмал хөхөрсөн үхжилтэй, ихэвчлэн хөлийн хурууны үзүүрээр
Субъектив байдал	Ажиглагдахгүй	Доголж явна



ОНОШИЛГОО

1. Тавхайн цусан хангамж шалгах

- Хөлийн арьсны халуун хүйтэн, хуурайшилтыг шалгах
- Тавхайн судасны лугшилтыг A.dorsalis pedis , a.tibialis posterior дээр тэмтэрч үзнэ
- Шагай бугалганы индекс тодорхойлох (ШаСД/БуСД Хэвийн=0,9-1,2)
- Доод мөчдийн судасны доплерграфийн шинжилгээ
- Доод мөчдийн судасны ангиографи



ОНОШИЛГОО

2.Тавхайн мэдрэлжүүлэлт алдагдлыг илрүүлэх

- Камертоноор доргионы мэдрэхүйг шалгах (тавхайн 1-р хуруун дээр, 7-с дээш насанд)
- Өвдөлтийн мэдрэхүйг шалгахдаа зориулалтын стандарт зүүг ашиглана
- Монофиламентийн арга: Semmes Weinstein-ний 10 граммын монофиламентийг ашиглана.
 - Өвчтний нүдийг аниулж тавхайн эвэршээгүй арьстай тодорхой 10 хэсгүүдэд перпендикуляр байрлуулж 3 сек орчим дарна.
 - 8-с дээш тооны даралтыг мэдэрсэн бол хэвийн
 - 1-7 бол мэдрэхүй буурсан



УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

- ЧШӨ-ний хяналтыг сайжруулах
- 1-ээс 3 сарын зайтай мэргэжлийн эмчийн зөвлөгөө
- Тавхайн даралтыг бууруулах тохиромжтой гутал тогмтол өмсөж байх
- Хөлний арьсны температурыг хянаж, үрэвслийн шинж тэмдэг илэрвэл нэмэлт хөл арчилгааг хийж байх
- Өмнө нь шарх үүсч байсан чихрийн шижинтэй өвчтөнд шинэ гэмтэлийг эрт илрүүлэх нь хүндрэлийн эрсдэлийг бууруулахад маш чухал ач холбогдолтой.
- Хөлийн эвэршилт болон улайлт нь шаархлаа үүсгэх өндөр магадлалтай.
- Шархыг дахиhaас сэргийлэхэд өвчтөний боловсрол чухал ач холбогдолтой
- Өөрөө өөртөө хяналт тавих үйл ажиллагаа



ЧШӨ-НИЙ ХӨЛИЙН ШАРХНЫ ЭДГЭРЭЛТ

- Үхэжсэн эдийг мэс заслаар авах, даралтын ачаалалгүй болгох, халдварлагдахаас сайтар сэргийлэх, судас эргэн сэргээх мэс засал хийснээр олон өвчтний хөлийн шархыг эдгээж хөл тайралтыг багасгаж байна.
- Европ дахь энэ чиглэлээр илүү мэргэшсэн эмнэлгүүдийн мэдээллээс харахад чихрийн шижинтэй өвчтний ойролцоогоор 77% нь 1 жилийн дотор эдгэрдэг.

Шархны эдгэрэлтийг муу болгох эмгэгүүд нь

- Зүрхний дутагдал
- Захын артерийн эмгэг
- Эцсийн шатанд орсон бөөрний эмгэгийн үед



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА

